



ХЭНТИЙ АЙМАГ
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 6/13

Бэрх

Б.Одод үр дүнгийн
урамшуулал олгох тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын" тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, "Төсвийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дах заалт, "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2, 1.2.2 дах заалт, 2.1, 2.2 дах заалт, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус хотын Соёлын ордны захирал Болдбаатарын Одод олгох 2025 оны эхний хагас жилийн ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хавсралтаар баталсугай.

2. Б.Одод олгох хагас жилийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг хавсралтад заасан хувиар холбогдох хууль, дүрэм журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАГЧ

Ч.ЭНХЖАВХЛАН

232501013

Хотын захирамжийн 2025 оны
08 дугаар сарын 22 ны өдрийн
6/13 дугаар захирамжийн хавсралт

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮР ДҮНГИЙН
МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ХУВЬ, ХЭМЖЭЭ

№	Овог нэр	Албан тушаал	Үнэлгээ	Хувь	Тайлбар
1	Б.Од	Соёлын ордны захирал	Хангалттай	30%	